

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/188/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сарын 15	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СУГ	Соёл урлагийн газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2023.02.15 № 2/15

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Баянхонгор аймгийн 4 сумын Соёлын төвд гаднын тоглолт зохион байгуулсан тоглолтын 8,873.0 мянган төгрөгийн орлогыг Соёл, урлагийн газрын төсвийн захирагч хувийн харилцах дансаараа дамжуулан авсан атлаа байрны түрээсийн төлбөрийн 10 хувь болох 887.3 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй;
- Тайлант оны эцэст төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,200.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, 2,700.0 мянган төгрөгийн 2 ширхэг үндсэн хөрөнгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нийлүүлээгүй байхад хөрөнгөд бүртгэсэн, жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор байгаагаар илэрхийлсэн;
- Аудитын явцад үндсэн хөрөнгөд биет тооллого явуулахад 540.0 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан;
- Төсвийн захирагчийн "Оюунлаг шүр" ХХК-тай байгуулсан гэрээнд 15,000.0 мянган төгрөгийн 7 нэр төрлийн 14 тоо ширхэг тоног төхөөрөмж авахаар заасан байхад худалдан авсан хөрөнгийн нэр төрөл, ширхэг гэрээний хавсралтаас зөрүүтэй, эдгээр хөрөнгийг 2022.03.15-ны өдөр 2 байгууллагын нягтлан бодогч нар

005020145

хүлээлцсэн актыг үйлдсэн боловч гарын үсгээр албажуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-73 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6 дахь “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалт, УСНББОУС 17, УСНББОУС 19, болон Оршин байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Соёл, урлагийн газар нь Соёл, урлагийн хэлтэс нэртэйгээр 2021 оны 11 дүгээр сараас 5 орон тоотой үйл ажиллагаа явуулж эхэлсэн, аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар үйл ажиллагааны зардал гарсан, Соёлын сайдын 2022.01.24-ны өдрийн А/04 дүгээр тушаалын дагуу Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газар болж, Соёл урлагийн хэлтэс, Захиргаа, удирдлагын хэлтэстэй, 11 орон тоо батлагдаж, 2022 онд 10 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Өмнөх онд улсын төсвөөс санхүүжилт олгоогүй, 2022 онд батлагдсан 212,616.5 мянган төгрөгийн төсвөөс 173,136.6 мянган төгрөгийг зарцуулсан, аудитаар сумдын Соёлын төвүүдэд тоглосон тоглолтын орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, төсвийн хөрөнгөөр худалдан авсан биет болон биет бус хөрөнгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нийлүүлээгүй байхад тооллогын бүртгэлд байгаагаар тоолж, бүртгэлд тусгасан, гэрээнд заасан хөрөнгийг худалдан аваагүй, аудитын биет тооллогоор хөрөнгө дутагдсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

### **Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтыг хэрэгжүүлэх 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Соёл, урлагийн газраас 91.8 хувиар тайлагнаж, Соёлын яаманд хүргүүлсэн, үнэлгээ тус газарт ирээгүй байна.

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b><u>7,742,700.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.00	400,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	400,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	0.00	7,342,700.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	0.00	280,000.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	280,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	0.00	7,062,700.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	1,548,500.00
35420	Аж ахуйн материал	0.00	5,514,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b><u>53,788,771.14</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	0.00	53,788,771.14
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	0.00	49,088,771.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	37,928,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(4,129,899.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	16,061,301.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(771,129.96)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	0.00	4,700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	4,700,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>0.00</b>	<b><u>61,531,471.14</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b><u>157,800.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	157,800.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	157,800.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	67,800.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.00	90,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	90,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b><u>61,373,671.14</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	0.00	61,373,671.14
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	0.00	61,373,671.14
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	61,373,671.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>0.00</b>	<b><u>61,531,471.14</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>0.00</b>	<b>280,724,301.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>34,059,801.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.00	34,059,801.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	34,059,801.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	20,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	34,039,801.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>246,664,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	0.00	212,616,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	212,616,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	34,048,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,298,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	31,750,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>219,350,629.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>219,350,629.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	178,335,697.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	122,256,218.29
210101	Үндсэн цалин	0.00	88,081,811.58
210102	Нэмэгдэл	0.00	13,371,918.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	15,995,000.00
210104	Урамшуулал	0.00	4,807,488.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	14,203,998.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	10,026,784.81
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,044,303.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	835,441.93
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	208,860.25
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	2,088,607.83
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	12,340,451.00
210401	Бичиг хэрэг	0.00	5,301,850.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	4,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	806,451.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,612,150.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	2,700,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	2,700,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	20,534,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	20,534,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	6,301,029.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	4,901,029.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	41,014,932.71
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	40,814,932.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	40,814,932.71
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>61,373,671.14</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>0.00</b>	<b>246,684,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>20,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.00	20,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	20,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	20,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>246,664,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	0.00	212,616,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	212,616,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	34,048,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,298,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	31,750,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>0.00</b>	<b>222,034,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>222,034,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>181,019,567.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	122,566,218.29
210101	Үндсэн цалин	0.00	90,014,071.04
210102	Нэмэгдэл	0.00	13,371,918.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	14,372,740.54
210104	Урамшуулал	0.00	4,807,488.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	14,203,998.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	10,026,784.81
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,044,303.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	835,441.93
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	208,860.25
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	2,088,607.83
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	6,199,901.00
210401	Бичиг хэрэг	0.00	4,038,600.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	1,202,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	806,451.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	152,850.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	31,883,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	31,883,750.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	6,165,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,165,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>41,014,932.71</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	40,814,932.71

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	40,814,932.71
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>24,650,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>24,650,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>24,650,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	0.00	24,650,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	24,650,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>(24,650,000.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	=
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	61,373,671.14	0.00	61,373,671.14
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	61,373,671.14	0.00	61,373,671.14

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	0
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	212,616,500.00	173,136,567.29	39,479,932.71	81.4
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	212,616,500.00	173,136,567.29	39,479,932.71	81.4
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	212,230,500.00	172,936,567.29	39,293,932.71	81.5
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	150,274,900.00	122,566,218.29	27,708,681.71	81.6
210101	Үндсэн цалин	101,036,800.00	90,014,071.04	11,022,728.96	89.1

210102	Нэмэгдэл	34,500,000.00	13,371,918.00	21,128,082.00	38.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000.00	14,372,740.54	(1,172,740.54)	108.9
210104	Урамшуулал	1,538,100.00	4,807,488.71	(3,269,388.71)	312.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,284,300.00</b>	<b>14,203,998.00</b>	<b>7,080,302.00</b>	<b>66.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,473,400.00	10,026,784.81	4,446,615.19	69.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,702,700.00	1,044,303.18	658,396.82	61.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,362,200.00	835,441.93	526,758.07	61.3
210204	Ажилгүйдлийн даатгал	340,500.00	208,860.25	131,639.75	61.3
210205	Эрүүл мэндийн даатгал	3,405,500.00	2,088,607.83	1,316,892.17	61.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,730,900.00</b>	<b>-</b>	<b>2,730,900.00</b>	<b>0</b>
210301	Гэрэл, цахилгаан	130,000.00	-	130,000.00	0
210302	Түлш, халаалт	2,152,900.00	-	2,152,900.00	0
210303	Цэвэр, бохир ус	448,000.00	-	448,000.00	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,288,500.00</b>	<b>6,199,901.00</b>	<b>88,599.00</b>	<b>98.6</b>
210401	Бичиг хэрэг	4,057,000.00	4,038,600.00	18,400.00	99.5
210402	Тээвэр, шатахуун	1,204,000.00	1,202,000.00	2,000.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	752,200.00	806,451.00	(54,251.00)	107.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,500.00	-	34,500.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,800.00	152,850.00	87,950.00	63.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,638,500.00</b>	<b>7,625,750.00</b>	<b>12,750.00</b>	<b>99.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,638,500.00	7,625,750.00	12,750.00	99.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,013,400.00</b>	<b>22,340,700.00</b>	<b>1,672,700.00</b>	<b>93.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,013,400.00	22,340,700.00	1,672,700.00	93.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>386,000.00</b>	<b>200,000.00</b>	<b>186,000.00</b>	<b>51.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>386,000.00</b>	<b>200,000.00</b>	<b>186,000.00</b>	<b>51.8</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	386,000.00	200,000.00	186,000.00	51.8
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>212,616,500.00</b>	<b>173,136,567.29</b>	<b>39,479,932.71</b>	<b>81.4</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>212,616,500.00</b>	<b>173,136,567.29</b>	<b>39,479,932.71</b>	<b>81.4</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	212,616,500.00	173,136,567.29	39,479,932.71	81.4
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>11.00</b>	<b>10.00</b>	<b>1.00</b>	<b>90.9</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	7.00	1.00	87.5
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	0.00	100
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>11.0</b>	<b>10.0</b>	<b>1.00</b>	<b>90.9</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	8.00	1.00	88.9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.00	2.00	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,733,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,733,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,733,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,958,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,958,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,775,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,775,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,733,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,733,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,298,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,435,000.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газар нь "Төрөөс баримтлах соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн онцлог хэв шинж бүхий соёлын өвд тулгуурлах хүн амыг соён гэгээрүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оршино" гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тус байгууллага нь Соёлын яамнаас дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Соёл, урлагийн хэлтэс, Захиргаа, удирдлагын хэлтэс гэсэн зохион байгуулалттай, төрийн үйлчилгээний 8, төрийн үйлчилгээний 2, нийт 10 орон тоотой үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Ц.Азбаясгалан, 2 дугаар гарын үсгийг 1-11 дүгээр сард нягтлан бодогч Г.Мөнхжаргал, 12 дугаар сараас нягтлан бодогч Б.Мөнхтогтох нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Архивын тухай хуулиудыг мөрдөж, үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Соёлын сайдын 2022.01.24-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар “Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтэц, дүрэм”-ийг баталсан;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;
- Байгууллагын хамт олны 2022.05.11-ний өдрийн хурлаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан;
- Байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээнд өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсний дагуу Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын 2023.01.04-ний өдрийн 10/24 дүгээр албан бичгээр зөвлөмжийг ирүүлсэн байна.

Тус аудитаар засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 2, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 2 зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгч, зөвлөмжийн биелэлтийг 2023.03.25-ны дотор ирүүлэхээр заасан байгаа тул эдгээр зөрчилд төрийн аудитын байгууллагаас давхардуулж зөвлөмж хүргүүлээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Соёлын сайдын 2022.01.11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллага 2022 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн, оны эцэст 60,031.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт А	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	400.0	400.0
Бараа материал	0	7,342.7	7,342.7
Үндсэн хөрөнгө	0	58,689.8	58,689.8
Хуримтлагдсан элэгдэл	0	(4,901.0)	(4,901.0)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>0</b>	<b>61,531.5</b>	<b>61,531.5</b>
Өр төлбөр	0	157.8	157.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0	61,373.7	61,373.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>0</b>	<b>61,531.5</b>	<b>61,531.5</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын залруулагдсан санхүүгийн тайлан

Байгууллагын М.Мөнхдалайд 2022 оны 1 дүгээр сард 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 18,856.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авснаас 11,514.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 7,342.7 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэйгээс 5,514.2 мянган төгрөг нь аж ахуйн материал байна.

Төсвийн хөрөнгөөр нийт 24,650.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, биет бус хөрөнгө худалдан авч, аймгийн ЗДТГ-аас 13 нэр төрлийн 15 ширхэг 6,580.0 мянган төгрөгийн тавилга, 1 ширхэг 49.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан байна.

Соёлын яамнаас тус байгууллагад тайлант онд 4,310.3 мянган төгрөгийн 5 нэр төрлийн 8 ширхэг үндсэн хөрөнгө ирүүлсэн байна.

Оны эцэст 157.8 мянган төгрөгийн өглөгтэй гарснаас 67.8 мянган төгрөг нь “Сүндэр констракшн” ХХК-т, 90.0 мянган төгрөг нь хамтын сангийн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 61,373.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул 2022 оны төсвийн төсөл боловсруулаагүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны төсвийг 212,616.5 мянган төгрөгөөр баталж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71702(Соёл урлаг) хөтөлбөрийн 80101 (үндсэн үйл ажиллагааны зардал), 80802 (ажил олгогчоос олгох тэтгэмж) арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс батлагдсан санхүүжилтийг бүрэн олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 173,136.5 мянган төгрөг буюу 81.4 хувьтай байгаа нь батлагдсан орон тооноос дутуу орон тоогоор ажилласнаас цалингийн зардал, байр ашиглалтын тогтмол зардал, бараа үйлчилгээний зардлууд хэмнэгдэж, оны эцэст 39,479.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ХӨТӨЛБӨР 71702-СОЁЛ УРЛАГ				
1.1	АРГА ХЭМЖЭЭ 80101 -Үндсэн үйл ажиллагааны зардал	212,230.5	172,936.5	39,293.0	81.5%
1.2	АРГА ХЭМЖЭЭ 80102-Ажил олгогчоос тэтгэмж	386.0	200.0	186.0	51.7%
	Дүн	212,616.5	173,136.5	39,479.9	81.4%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын батлагдсан төсвийн хуваарь, төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Соёлын сайдын холбогдох тушаалуудын дагуу 2022 оны тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 34,048.0 мянган төгрөгийн орлого орсон ба оны эцэст санхүүжилтийн үлдэгдэл 1,315.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн хөрөнгөд тавих дотоод хяналтыг сайжруулах, төсвийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг тухай бүрд гаргаж байх, хоолны мөнгө, цалин хөлсийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгох, үндсэн хөрөнгийг гэрээнд заасны дагуу чанартай, бүрэн нийлүүлсэн эсэхэд эргэн хяналт тавих, үндсэн хөрөнгийн шинж чанаргүй хөрөнгийг бараа материалд шилжүүлэн бүртгэх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.01.03-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 212,616.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,189.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,232.5 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын даргын 2022.10.05-ны өдөр Санхүү, хөрөнгө оруулалтын газарт төсөвт зохицуулалт хийлгэх тухай 92 дугаар албан бичгийг хүргүүлж, орон тооны дутуугаас цалингийн нэмэгдлийн зардал хэмнэгдсэнийг бараа үйлчилгээний зардалд 20,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн хуваарилах хүсэлтийг хүргүүлж, зардлыг дээд шатны байгууллагаас баталж өгсөн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 119,772.6 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 19,950.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 12,565.0 мянган төгрөгийн 4 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 124,207.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ, 19,950.0 мянган төгрөгийн 1 шийдвэр болон тайлант онд бусад аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан 32,050.0 мянган төгрөгийн 3 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газар 2022 оноос батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул өмнөх онд аудит хийгдээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Соёлын яамнаас баталсан төсвийн хуваарьт төрийн үйлчилгээний ажилтныг 3 орон тоогоор баталсан байхад Соёлын сайдын 2022.01.24-ний өдрийн А/04 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтад 2 орон тоогоор баталсан, гүйцэтгэлээр 2 хүн ажиллаж байгааг цаашид анхаарах нь зүйтэй байна.

Тухайн байгууллага байгуулагдсан хугацаанаас хойш хандив тусламжаар ирсэн хөрөнгийн орлого болон хадгалалт хамгаалалтын талаар завсрын аудитаар тодруулан үзэх нь зүйтэй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 1,500.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. "Хас эрин орчин" ХХК-аас 2022.06.13-ны өдөр 1,500.0 мянган төгрөгийн санхүүгийн программыг худалдан авч, биет бус хөрөнгөд бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан байгаа тул биет бус хөрөнгөд бүртгэж санхүүгийн тайланг залруулав.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 39,914.3 мянган төгрөгийн 9 зөрчил<sup>2</sup> илэрснээс 7,727.0 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 28,950.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 3,237.3 мянган төгрөгийн дүн бүхий 4 зөвлөмжийг өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Баянхонгор аймгийн 4 сумын Соёлын төв дөрвөн соёлын тэргүүний ажилтны тоглолтын 8,873.0 мянган төгрөгийн орлогоос түрээсийн төлбөрт 10 хувиар тооцон аваагүй, Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын төсвийн захирагчийн хувийн дансанд шилжүүлсэн байхад 887.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэснийг зөрчсөн тул байгууллагын төсвийн захирагчаар нөхөн төлүүлэн, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын дарга, нягтлан бодогч нар иргэн Т.Дагвадоржтой вэб хөгжүүлэхээр гэрээг 2022.09.11-ний өдрөөс 2022.12.14-ны өдөр хүртэлх хугацаатай байгуулж, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 210801 зардлаас 2022.12.20-ны өдөр 3,200.0 мянган төгрөгийг иргэний дансанд шилжүүлж, орлогоор бүртгэсэн ба аудитаар шалгахад вэб сайт ашиглалтад ороогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн тул иргэн Т.Дагвадоржоор төлүүлж, орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор хөрөнгө дутагдаагүй байсан ба аудитаар байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгөд 2023.02.09-ны өдөр биет тооллого хийхэд 540.0 мянган төгрөгийн принтер, 1,500.0 мянган төгрөгийн проектор, 1,200.0 мянган төгрөгийн угтвар ширээ тооллогоор дутагдсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 дэх "Тооллогын комисс дараах үүрэгтэй: эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 72.5.1 дэх "Тооллогын комисс дараах эрхтэй: тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн тул төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. Байгууллагын даргын 2021.11.01-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар соёл гэгээрэл инноваци хариуцсан мэргэжилтнээр томилогдсон М.Мөнхдалайд 2022 оны 1 дүгээр сард 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, 1 дүгээр сарын цалингаас суутгал хийгээгүй, тус ажилтан байгууллагын даргын 2022.02.01-ний өдрийн Б/09 дүгээр тушаалаар ажлаас чөлөөлөгдөж, холбогдох тооцоог хийгээгүйгээс цалингийн урьдчилгааны авлага барагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй: төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн тул байгууллагын төсвийн захирагчаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

Баянхонгор аймгийн Соёл урлагийн газрын дарга "Оюунлаг шүр" ХХК-тай 2022.01.30-ны өдөр бараа худалдах, худалдан авах 22/01 тоот гэрээ байгуулж, 7 нэр төрлийн 14 тоо ширхэг тоног төхөөрөмж авахаар заасан байна. Тус гэрээнд заасан тоног төхөөрөмжийг нэр төрөл, ширхгээр нь аваагүй, тоног төхөөрөмжийг 2022.03.15-ны өдөр 2 байгууллагын нягтлан бодогч нар хүлээлцсэн актыг үйлдсэн боловч гарын үсгээр албажуулаагүй байна. Мөн орон тооны хэмнэлтээс 2022 оны 10 дугаар сард цалингийн зардлын нэмэгдэл хөлсний зардал хэмнэгдэж, хэмнэлтийн 20,000.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд нэмж тодотгон, "Айети юнипикшн" ХХК-тай 2022.12.12-ны өдөр 13,950.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, үндсэн хөрөнгө бэлтгэсэн байхад бараа материалын тайланд тус аж ахуйн нэгжээс 2022.11.15-ны өдөр хөрөнгийг авсан баримтыг хавсаргасан, 2 үндсэн хөрөнгө ирээгүй байхад жилийн эцсийн тооллогоор биетээр байгаагаар тоолсон ба эдгээр хөрөнгүүдийг хүлээн авах комиссыг томилоогүй, гэрээнд заасан нэр төрөл, хөрөнгийн чанар байдалд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 дэх “Тооллогын комисс дараах үүрэгтэй: эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.5.1 дэх “Тооллогын комисс дараах эрхтэй: тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах” гэснийг зөрчсөн байна. Иймд "Оюунлаг шүр" ХХК, "Айети юнипикшн" ХХК-тай байгуулсан гэрээнд заасан үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, чанарт хяналт тавих комиссыг томилж, хөрөнгийн тулгалтыг дахин хийж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын төсвийн захирагч хөрөнгө зарцуулах, үндсэн хөрөнгийг орлогод авах тушаал гаргаагүй, гэрээг албажуулалгүй хөрөнгийг захиран зарцуулсан, соёл урлагийн ажилтны өдрийг тэмдэглэх удирдамжаар 2022.09.08-ны өдөр 880.0 мянган төгрөгийг хүнсний худалдаа эрхлэгч иргэн Оюунд шилжүүлж, бичгийн цаас,

ханын цаас, ном авсан зэргээр төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулж, байгууллагын төсвийн захирагчаас хөрөнгө зарцуулах шийдвэрийг тухай бүрд гаргаж, бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах

## 2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдын цагийн бүртгэлийг бүрэн хөтлөөгүй, өвчтэй чөлөөтэй, чөлөөний хуудсыг хавсаргаагүй байхад цалин хөлсийг бүрэн тооцож олгосон, байгууллагын даргын 2022.06.03-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар Г.Бүжинлхамыг тухайн өдрөөс эхлэн соёл гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилсон байхад нэг өдрийн цалинд 35.6 мянган төгрөгийг илүү олгосон байна. Мөн байгууллагын даргын 2022.02.01-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Цэрмаагийн цалинг тус өдрөөс 813,215 төгрөг болгож нэмэгдүүлсэн байхад цалингийн зөрүүг тооцож олгоогүй, архив, бичиг хэрэг, нярваар Г.Цэцэгмааг 2022.09.12-ны өдрөөс томилсон байхад цалинг 10 дугаар сард зөрүүтэй тооцож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь “Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй”, Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын хамтын гэрээний 5.1.2-т заасан “Ажилтан өглөө ажилдаа ирсэн, завсарласан, ажлаас орой тарсан цагаа бүртгүүлнэ. Ажлын цагийн бүртгэлийн тайланг сар бүр нярав гаргаж нэгжийн даргад танилцуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох шийдвэрийг үндэслэн, албан хаагчдын цагийн бүртгэлийн тайлан, шийдвэрийн дагуу ажилласан хугацаа, цагийг үнэн зөв тооцож, цалин хөлсийг олгож байх

## 3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын батлагдсан төсөвт унаа хоолны хөнгөлөлтөд 13,200.0 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 15,995.0 мянган төгрөгийг олгож, батлагдсан зардлаас 2,795.0 мянган төгрөгийг илүү олгосон нь албан хаагчдад 2022 оны 7 дугаар сараас унаа хоолны мөнгийг 5000-аас 10000 төгрөгөөр тооцож олгосонтой холбоотой бөгөөд хоолны мөнгийг нэмэх шийдвэрийг төсвийн захирагчаас гаргаагүй, хамтын гэрээний заалтыг үндэслэн хоолны мөнгийг олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны байгууллагаас баталсан төсвийн хүрээнд хоолны мөнгийг олгох, Сангийн сайдын 2022.06.02-ны өдрийн 120 дугаар тушаалын 1 дэх заалтыг мөрдөж, томилолтоор ажилласан хугацааны хоолны зардал, хоолны мөнгийг давхардуулан олгохгүй байх.

## 4. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аппарат, далбаа, тамганы хайрцаг, хаяг, тамга зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 442.3 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй хөрөнгийг бараа материалд шилжүүлэн бүртгэх

## 5. Нийцлийн холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулган шалгахад 124,207.9 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, хөрөнгө захиран зарцуулах 19,950.0 мянган төгрөгийн 1 шийдвэр, аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан 32,050.0 мянган төгрөгийн 3 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст

байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэснийг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын шилэн дансанд байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, цаашид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
"Хас эрин орчин" ХХК-аас 2022.06.13-ны өдөр 1,500.0 мянган төгрөгийн санхүүгийн программыг худалдан авч, биет бус хөрөнгөд бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан.	1	1,500.0	0	0	1	1,500.0	1	1,500.0				
Дүн	1	1,500.0	0	0	1	1,500.0	1	1,500.0	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Баянхонгор аймгийн 4 сумын Соёлын төв дөрвөн соёлын тэргүүний ажилтны тоглолтын 8,873.0 мянган төгрөгийн орлогоос түрээсийн төлбөрт 10 хувиар тооцон аваагүй, Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын төсвийн захирагчийн хувийн дансанд шилжүүлсэн байхад 887.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	1	887.0	1	887.0									
Байгууллагын дарга, нягтлан бодогч нар иргэн Т.Дагвадоржтой вэб хөгжүүлэхээр гэрээг 2022.09.11-ний өдрөөс 2022.12.14-ны өдөр хүртэлх хугацаатай байгуулж, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 210801 зардлаас 2022.12.20-ны өдөр 3,200.0 мянган төгрөгийг иргэний дансанд шилжүүлж, орлогоор бүртгэсэн байхад аудитаар шалгахад вэб сайт ашиглалтад ороогүй байна.	1	3,200.0	1	3,200.0									
Аудитаар байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгөд 2023.02.09-ны өдөр биет тооллого хийхэд 540.0 мянган төгрөгийн принтер, 1,500.0 мянган төгрөгийн проектор, 1,200.0 мянган төгрөгийн угтвар ширээ тооллогоор дутагдсан.	1	3,240.0	1	3,240.0									
Байгууллагын даргын 2021.11.01-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар соёл гэгээрэл инноваци хариуцсан мэргэжилтнээр томилогдсон М.Мөнхдалайд 2022 оны 1 дүгээр сард 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, 1 дүгээр сарын цалингаас суутгал хийгээгүй, тус ажилтан байгууллагын даргын 2022.02.01-ний өдрийн Б/09 дүгээр тушаалаар ажлаас чөлөөлөгдөж, холбогдох тооцоог хийгээгүйгээс	1	400.0	1	400.0									

цалингийн урьдчилгааны авлага барагдаагүй байна.												
Баянхонгор аймгийн Соёл урлагийн газрын дарга "Оюунлаг шүр" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хөрөнгийг аваагүй, худалдан авсан хөрөнгийн тоо ширхэг, нэр төрөл зөрүүтэй, хөрөнгийг хүлээлцсэн акт хүчин төгөлдөр бус, "Айети юнипикшн" ХХК-аас хөрөнгийг бүрэн аваагүй, хөрөнгө хүлээлцсэн акт байхгүй, тус хөрөнгүүдийг хүлээн авах комиссыг томилоогүй, хөрөнгийн чанар байдалд хяналт, үнэлгээ хийгээгүй байна.	1	28,950.0			1	28,950.0						
Байгууллагын төсвийн захирагч хөрөнгө зарцуулах, үндсэн хөрөнгийг орлогод авах тушаал гаргаагүй, гэрээг албажуулалгүй хөрөнгийг захиран зарцуулсан, Соёл урлагийн ажилтны өдрийг тэмдэглэх удирдамжаар 2022.09.08-ны өдөр 880.0 мянган төгрөгийг хүнсний худалдаа эрхлэгч иргэн Оюунд шилжүүлж, бичгийн цаас, ханын цаас, ном авсан ба төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй.	1	-					1	-				
Албан хаагчдын цагийн бүртгэлийг бүрэн хөтлөөгүй, өвчтэй чөлөөтэй, чөлөөний хуудсыг хавсаргаагүй байхад цалин хөлсийг бүрэн тооцож олгосон, 3 албан хаагчийн цалинг зөрүүтэй тооцож олгосон байна.	1	0.0					1	0.0				
Байгууллагын батлагдсан төсөвт унаа хоолны хөнгөлөлтөд 13,200.0 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 15,995.0 мянган төгрөгийг олгож, батлагдсан зардлаас 2,795.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. Албан хаагчдад 2022 оны 7 дугаар сараас унаа хоолны мөнгийг 5000-аас 10000 төгрөгөөр тооцож олгох шийдвэрийг гаргаагүй, хамтын гэрээний заалтыг үндэслэн хоолны мөнгийг олгосон байна.	1	2,795.0					1	2,795.0				
Үндсэн хөрөнгөд аппарат, далбаа, тамганы хайрцаг, хаяг, тамга зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 442.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.	1	442.3					1	442.3				
Дүн	9	39,914.3	4	7,727.0	1	28,950.0	4	3,237.3	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулган шалгахад 124,207.9 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, хөрөнгө захиран зарцуулах 19,950.0 мянган төгрөгийн 1 шийдвэр, аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан 32,050.0 мянган төгрөгийн 3 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	1	0					1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	

---oOo---